

**МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА
МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

Товч танилцуулга

Хуулийн төслийг боловсруулах болсон шаардлага

Төрийн үйл ажиллагааны ил тод,
нээлттэй, шударга, шуурхай, хариуцлагатай,
ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангах

Иргэдийн мэдээлэл авах эрх, эрх чөлөөг
хангах нөхцөлийг бүрдүүлэх

Хуулийн төслийн бүтэц

Хуулийн төсөл 6 бүлэг, 25 зүйлтэй:

1-р бүлэгт хуулийн зорилт, мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёоны тодорхойлолт болон мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах үйл ажиллагаанд баримтлах зарчмын тухай;

... үргэлжлэл

- 2-р бүлэгт мэдээллийн ил тод, нээлттэй байдлын төрөл, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор төрийн байгууллага /Олон нийтийн радио, телевиз/-аас авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай;

... үргэлжлэл

- 3-р бүлэгт иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрх чөлөө, төрийн байгууллага /Олон нийтийн радио, телевиз/-аас иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл өгөх журмын тухай;

... үргэлжлэл

- 4-р бүлэгт зарим төрлийн мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөхийг хориглох тухай;

... үргэлжлэл

- 5-р бүлэгт мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих тухай;

... үргэлжлэл

- 6-р бүлэгт мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага болон хууль хүчин төгөлдөр болох хугацааг.

Хуулийн үйлчлэх хүрээ

- Улсын Их Хурлын Тамгын газар;
- Ерөнхийлөгчийн Тамгын газар;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба;
- төрийн захиргааны төв болон захиргааны байгууллага;
- шүүх, прокурорын байгууллага /бүх шатны/;
- Улсын Их Хурлаас байгуулдаг /Засгийн газраас бусад/ байгууллага;

... үргэлжлэл

- нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын ажлын алба,
- орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд; төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллага; Олон нийтийн радио, телевиз.

... үргэлжлэл

- Энэ хууль зэвсэгт хүчин, хилийн болон дотоодын цэрэг, тагнуулын байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангахад хамаарахгүй.
- Төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангахад Байгууллагын нууцын тухай хууль үйлчлэхгүй.

Мэдээллийн ил тод, нээлттэй байдал

Мэдээллийн ил тод, нээлттэй байдал дараахь төрөлтэй байна:

- үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал;
- хүний нөөцийн бодлогын ил тод, нээлттэй байдал;
- төсөв, санхүүгийн ил тод, нээлттэй байдал;
- төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдал.

Мэдээлэл авах эрх, эрх чөлөө

- Иргэн, хуулийн этгээд нь хүний эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад дараахь мэдээллийг энэ хуулийн 3.1-д заасан байгууллагаас авах эрхтэй:

... үргэлжлэл

- тухайн байгууллагын эзэмшилд байгаа бүх төрлийн мэдээ, баримт бичиг, гэрээ, контракттай холбоотой мэдээлэл;
- тухайн байгууллагын эзэмшилд байгаа эд зүйлтэй холбоотой мэдээлэл;
- тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл.

... үргэлжлэл

- Энэ хуулийн 11.1-д заасан тохиолдолд бичгээр хүсэлт гаргана. Иргэн, хуулийн этгээд хүсэлт гаргасан үндэслэлээ тайлбарлах үүрэггүй.

... үргэлжлэл

- Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага нь тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжид нийтэд мэдээлэхийг хориглоогүй мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд өгөх үүрэгтэй.
- Мэдээллийг амаар, бичгээр, цахим хэлбэрээр өгч болно. Иргэн, хуулийн этгээд нь мэдээлэлтэй биечлэн танилцаж болно.

... үргэлжлэл

- Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд ажлын 7 хоногийн дотор өгнө. Мэдээлэл авах хүсэлтийг иргэд хамтран гаргасан бол тэдгээрийн төлөөлөл болох нэг иргэнд мэдээллийг өгнө.

Цахим хэлбэрээр мэдээлэл авах

- Иргэн, хуулийн этгээд цахим хэлбэрээр мэдээлэл авах хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд иргэн, хуулийн этгээд нь цахим баримт бичиг үйлдэн, тоон гарын үсэг зурах бөгөөд түүнд өөрийн иргэний үнэмлэхийн, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын дугаарыг бичин холбогдох байгууллагад цахим шуудангаар ирүүлсэн байна.

... үргэлжлэл

- Мэдээллийг цахим хэлбэрээр иргэн, хуулийн этгээдэд өгөх тохиолдолд тухайн байгууллагыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан цахим баримт бичиг үйлдэж, тоон гарын үсэг зурах бөгөөд хүсэлт гаргагчид мэдээллийг цахим шуудангаар хүргүүлнэ.

Үйлчилгээний хөлс

- Иргэн, хуулийн этгээд мэдээлэл авах тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө. 15.2.Үйлчилгээний хөлсний хэмжээг тухайн мэдээллийг өгөх зардалтай нийцүүлэн байгууллагын удирдлага тогтооно. Үйлчилгээний хөлс тооцох аргачлал, үйлчилгээний хөлс төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журмыг Засгийн газар батална.

Гомдол гаргах

- Иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрхийг зөрчсөн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдлийн талаар дээд шатны байгууллага, албан тушаалтан, Хүний эрхийн үндэсний комисс, эсхүл шүүхэд гомдол гаргаж болно.

Онцгой нөхцөл

- Тухайн мэдээллийг нийтэд ил болгосноор Монгол Улсын олон улсын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх бодитой үндэслэл байгаа бол;
- Тухайн мэдээллийг нийтэд ил болгосноор Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашигт хохирол учруулах бодитой үндэслэл байгаа бол;

... үргэлжлэл

- Тухайн мэдээлэл нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, өрсөлдөөний болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хяналт шалгалтын шатанд байгаа хэрэг явдалтай холбоотой бол;

... үргэлжлэл

- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай бол;
- Тухайн мэдээлэл нь олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах явцтай холбоотой бол;

Хувь хүний нууцыг хамгаалах

- Хуульд өөрөөр заагаагүй бол хувь хүн бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд түүний овог, нэр, нас, хүйс, мэргэжил, боловсрол, албан тушаал, ажлын газрын хаяг, ажлын утаснаас бусад мэдээллийг бусдад задруулахыг хориглоно

Оюуны өмчийг хамгаалах

- Оюуны өмчтэй холбоотой мэдээллийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно.

Хувь хүний нууцыг хамгаалах

- Хуульд өөрөөр заагаагүй бол хувь хүн бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд түүний овог, нэр, нас, хүйс, мэргэжил, боловсрол, албан тушаал, ажлын газрын хаяг, ажлын утаснаас бусад мэдээллийг бусдад задруулахыг хориглоно

Байгууллагын нууцыг хамгаалах

- Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжтэй холбоотой мэдээллийг тухайн аж ахуйн нэгжийн эрх бүхий этгээд /гүйцэтгэх удирдлага буюу түүнээс эрх олгосон бусад этгээд/-ийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно.

Хуулийн хэрэгжилт

- Төсвийн ерөнхийлөн захирагч нартай байгуулах үр дүнгийн гэрээнд мэдээллийн ил тод байдлыг хангах талаар тусгаж, үнэлгээний гол шалгуурын нэг болгон дүгнэж байна.

Хариуцлага

- Иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл авах эрх, эрх чөлөөг удаа дараа буюу ноцтой зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчийг эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 25.1.1-д заасан үндэслэлээр төрийн албанаас хална.



АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА!